



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч
томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 6 дугаар зүйлийн 6.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. П.Цэцгээгийн нэхэмжлэлтэй Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн Б/23 дугаар тушаалд өөрчлөлт оруулахыг даалгах, 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Б/200 дугаар “Албан тушаалаас чөлөөлөх тухай” тушаалыг хүчингүй болгох, албан тушаалд эгүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговрыг гаргуулах, нийгмийн болон эрүүл мэнийн даатгалыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийн шаардлага бүхий Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Захиргаа, удирдлагын газрын хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Батбаяр, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Батзориг нарыг оролцуулахаар итгэмжлэл олгосугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Батбаяр, Л.Батзориг нарт Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг олгож, хянан шийдвэрлэх ажиллагаанд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг төлөөлүүлж, оролцуулсугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангах, хяналт тавих, шаардлагатай материалаар ханган ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Намхайноров)-т үүрэг болгосугай.

ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Д.УРАНЗАЯА



142022 01016